

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах  
үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай” Монгол Улсын Шадар сайд М.Энхболдын сонсгол-мэдээллийг хэлэлцээд, “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үндэсний чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө”-ний төслийг зөвшөөрч, дараах асуудлыг чиглэл болгов. Үүнд:

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчид:

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үндэсний чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохицуулах байнгын ажиллагаатай, орон тооны бус зөвлөлийг Шадар сайд (М.Энхболд)-аар ахлуулан байгуулах чиглэлийг Засгийн газарт өгсөн зарлиг гаргах.

Хоёр. Монгол Улсын Их Хуралд:

“Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үндэсний чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан зохих хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл болон 2011 оны улсын төсвийн тодотгол, 2012 оны улсын төсөвт тусгах арга хэмжээний хөрөнгө, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх.

Гурав. Монгол Улсын Засгийн газарт:

1. “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах үндэсний чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө”-г баталж, хэрэгжилтийг зохион байгуулах.

2. Монгол Улсын Ерөнхийлөгч 2011 оны Улсын Их Хурлын хаврын чуулганд Үндэсний аюулгүй байдлын асуудлаар мэдээлэл хийхтэй холбогдуулан газар хөдлөлтийн болзошгүй гамшгийн бодит аюул, занал, түүнээс хамгаалах, эрсдэлийг бууруулах чиглэлээр хийж буй ажлын явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл бэлтгэх.